

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ БӨХИЙН МАЛГАЙ, ӨМСГӨЛИЙН ХИЙЦ ЗАГВАРЫН СТАНДАРТ

Д.Сэрээтэр, дэд профессор, Х. Чойжилжав, магистр, УБТС

Abstract

Hat: Hat of Mongolian national wrestler has been changed into hierarchy accordingly wrestler's odd's hierarchy. It could be notified that how many times the wrestler had taken 2nd place in the national festival by his yellow tape on the red fringe of his hat. Indeed, it has opened an absolute new page to enrich history ever since Mongolian wrestlers started wearing honorable hat. In addition, the hat of Mongolian race horse trainer, toxiphilite and knucklebone player had been taken idea from hat of wrestlers.

Zodog: The outfit that wrestler wears on his upper body is called zodog and the shuudag is for his lower body outfit. The colors of zodog and shuudag symbolizes sky by red, pink, purple and blue. Sewing of zodog and shuudag is tailored in 3 rows, that express men's 3 festival of Mongolia is celebrated simultaneously and one of them is Mongolian wrestling. Number of sewing rows are tailored in odd numbers as always, showing that odd numbers symbolize happiness when happiness and sadness are taking shifting, and the middle sewing shaped as a Rombo highlights unlimited universe. Furthermore, there are some legends signifying that Mongolian zodog used to be closed in the front side and turned to opened design. The benefits of the opened zodog is more suitable to wrestling and fighting and boosts the appearance of wrestlers.

Boots: Boots of Mongolian wrestler is Mongolian traditional boots or could be boots with leather. Boots of wrestler should have pressure of halter and back of the thigh.

Түлхүүр үг: Зодог, шуудаг, залаа, тууз

Зорилго: Монгол үндэсний бөхийн өмсгөлийг залуу хойч үедээ таниулах, уламжлан хадгалах, бахархах

Удиртгал


Малгай: Монгол үндэсний бөхийн малгай нь бөхчүүдийн цолны эрэмбэ шиг өөр өөрийн эрэмбэ дараалалтай өвөрмөц онцлогтой болсон. Малгайн улаан залаан дээрх шар туузаар улсын их баяр наадамдаа хэдэн даваагаар хэд шөвгөрсөн алдартан бэ? гэдгийг мэдэх болцгоосон юм. Ийнхүү Монголын бөхчүүд хүндэтгэлийн малгайтай болсноор монгол бөхийн түүх нэгэн шинэ зүйлээр баяжсан билээ. Тэрчлэн монгол бөхийн малгайн залаанаас санаа авч уяачид, сурчид, шагайчид тусгай малгайтай болж байна.

Зодог: Бөх хүний барилдахдаа цээжин биендээ өмсөх өмсгөлийг зодог, зодогны доогуур хэсгээр өмсөх өмсгөлийг шуудаг гэдэг. Зодог, шуудгийг гал, газар, тэнгэрийг билэгдэн улаан, ягаан, ухаа, хөх, цэнхэр өнгөөр голчлон хийдэг. Монгол бөхийн зодог шуудагны ширээс зэрэгцсэн гурван эгнээ байдаг нь монголчуудын эрийн гурван наадам нэг дор хэрэгжиж байгаагийн илэрхийлэл бөгөөд түүний нэг нь Монгол бөх гэдгийг харуулж байдаг.

Ширээсний эгнээнүүдийн тоо ямагт сондгой тоогоор хийгддэг нь жаргал, зовлон хэмээн ээлжлэн бэлгэдэхэд сондгой тоо нь жаргалыг илэрхийлж байдаг бол Ромбо хэлбэртэй голын ширээс нь хязгааргүй орчлын бэлгэ тэмдэг байдаг байна. Урьд бөхийн зодог нь урдуураа битүү байсныг задгай болгосон тухай домгууд ч байдаг. Үүний нэг нь зохиолч З.Сандагийн бичсэнээр “Монгол бөхийн зодог урдуураа битүү байсан урьдын үед нэгэн хүчит эмэгтэй наадамд ахаа төлөөлөн барилдаж үзүүр түрүү булаацалдах барилдаанд хүрээд байхдаа эмэгтэй хүн гэдэг нь илэрч түүнээс хойш зодогны урд талыг задгай болгож, элэг бүс хэмээх зүйл бий болсон гэдэг” Гэвч зодогны урд талыг задгай болгосны гол ач холбогдол нь барилдах ноцолдоход үлэмж тохиромжтой, бөхийн гадаад үзэмж маягийг улам дээшлүүлсэнд оршиж байгаа юм.

Гутал: Монгол бөхийн гутал нь монгол гутал байх ба савхин түрийтэй гутал байж болно. Бөхийн гутал нь ногт, хонгоны даралттай байна.

Үндсэн хэсэг



Арслангийн малгай:

Монголын үндэсний бөхийн арслан цолтой бөхийн малгай нь улаан өнгийн эдээр өнгөлсөн шовх орой бүхий бөгөөд дөрвөн босоо чихтэй, хойд урд талын чих нь жижиг, хоёр хажуу талын чих арай том байна. Малгайн оройн таван хошууны завсар чихний эмжээр цэнхэр өнгийн хавчаартай байна. Дөрвөн чихийг хар өнгийн хилэнгээр өнгөлнө.

Малгайн оройн багананд нь цагаан мөнгөөр 7.0 см-ийн урттай таван галын дөлийг дээш нь бадруулан босгож, үзүүр дээр нь бат бөх байхыг бэлгэдсэн 0.5 см-ийн зузаантай гурван цагираг байх ба 1.5 см өндөр гурван цагирагны дээр монгол үндэстэн ястнууд эв нэгдэлтэй байхыг бэлгэдэн, сампинг мөнгөөр цутгаж хийгээд шармалдсан байна. Сампингийн өндөр 4.0 см байна.

Малгай урд талын чихэн дээрээ арслангийн алтадсан дүрсийг 5.5 см-ийн голчтой дугуй дээр хагас хөндлөн харуулан товойлгож урласан тэмдэгтэй байна. Арслангийн малгайн залаа нь улаан өнгөтэй хос залаа байх бөгөөд урт нь 65 см, үзүүр талаараа 8.0 см-ийн өргөн, уг хэсгээрээ 4.0 см-ийн өргөнтэй байна.

Улсын наадамд түрүүлсэн арслангийн өнгөн талын залаан дээр үзүүрээсээ 0.5 см-ийн зайд 2.5 см өргөн шар туузтай, түрүүлээгүй арслангийн өнгөн талын залаа цулгүй, хоёр дахь залаан дээр үзүүр талаасаа 0.5 см-ийн зай үлдээгээд, бага шөвөг 0.5 см, дунд шөвөг 0.1 см, их шөвөгт үлдсэн бол 1.5 см, үзүүрт үлдсэн бол 2.0 см-ийн өргөнтэй шар туузыг амжилтын тоогоор хооронд нь 0.5 см-ийн зайтай оёсон байна. Залаанд өөр чимэглэл хийхгүй.



Гарьдын малгай:


Монголын үндэсний бөхийн гарьд цолтой бөхийн малгай нь улаан өнгийн эдээр өнгөлсөн шовх орой бүхий бөгөөд дөрвөн босоо чихтэй, хойд урд талын чих нь жижиг, хоёр хажуу талын чих арай том байна. Малгайн оройн таван хошууны завсар чихний эмжээр цэнхэр өнгийн хавчаартай байна.

Дөрвөн чихийг хар өнгийн хилэнгээр өнгөлнө.

Малгайн оройн багананд нь цагаан мөнгөөр 7.0 см-ийн урттай таван галын дөлийг дээш нь бадруулан босгож, үзүүр дээр нь бат бөх байхыг бэлгэдсэн 0.5 см-ийн зузаантай гурван цагираг байх ба 1.5 см өндөр гурван цагирагны дээр монгол үндэстэн ястнууд эв нэгдэлтэй байхыг бэлгэдэн, сампинг мөнгөөр цутгаж хийгээд шармалдсан байна. Сампингийн өндөр 4.0 см байна.

Малгай урд талын чихэн дээрээ могой зуугаагүй хангарьдын дүрсийг 5.5 см-ийн голчтой дугуй дээр хагас хөндлөн харуулан товойлгож урласан тэмдэгтэй байна. Гарьдын малгайн залаа нь улаан өнгөтэй хос залаа байх бөгөөд урт нь 60 см, үзүүр талаараа 8.0 см-ийн өргөн, уг хэсгээрээ 4.0 см-ийн өргөнтэй байна.

Малгайн хоёр дахь залаан дээр үзүүр талаасаа 0.5 см-ийн зай үлдээгээд, бага шөвөг 0.5 см, дунд шөвөг 1.0 см, их шөвөгт үлдсэн бол 1.5 см, үзүүрт үлдсэн бол 2.0 см-ийн өргөнтэй шар туузыг амжилтын тоогоор хооронд нь 0.5 см-ийн зайтай оёсон байна. Залаанд өөр чимэглэл хийхгүй.



Зааны малгай: Монгол үндэсний бөхийн заан цолтой бөхийн малгай нь улаан өнгийн эдээр өнгөлсөн шовх орой бүхий бөгөөд дөрвөн босоо чихтэй, хойд урд талын чих нь жижиг, хоёр хажуу талын чих арай том байна. Малгайн оройн таван хошууны завсар чихний эмжээр цэнхэр өнгийн хавчаартай байна.

Дөрвөн чихийг хар өнгийн хилэнгээр өнгөлнө. Малгайн оройн багананд нь цагаан мөнгөөр 7.0 см-ийн урттай таван галын дөлийг дээш нь бадруулан босгож, үзүүр дээр нь бат бөх байхыг бэлгэдсэн 0.5 см-ийн зузаантай хоёр цагираг байх ба нийт 1.0 см зузаан хоёр цагирагны дээр монгол үндэстэн, ястнууд эв нэгдэлтэй байхыг бэлгэдэж сампинг мөнгөөр цутгаж хийх ба сампингийн өндөр 4.0 см байна.

Малгай урд талын чихэн дээрээ мөнгөн зааны дүрсийг 5.5 см-ийн голчтой дугуй дээр хагас

хөндлөн харуулан товойлгож урласан тэмдэгтэй байна. Зааны малгайн залаа нь улаан өнгөтэй хос залаа байх бөгөөд урт нь 55.0 см, үзүүр талаараа 7.0 см-ийн өргөн, уг хэсгээрээ 3.5 см-ийн өрнөгтэй байна. Өнгөн талын залаа цулгуй, хоёр дахь залаан дээр үзүүр талаасаа 0.5 см-ийн зай үлдээгээд 7 давсан бол 1.5 см, бага шөвөгт үлдсэн буюу 5 давсан бол 0.5 см, дунд шөвөг буюу 6 давсан бол 1.0 см өргөнтэй шар туузыг амжилтын тоогоор нь хооронд нь 0.5 см-ийн зайтай оёсон байна. Залаанд өөр чимэглэл хийхгүй.

Харцагын малгай: Монгол үндэсний бөхийн харцага цолтой бөхийн малгай нь улаан өнгийн эдээр өнгөлсөн шовх орой бүхий бөгөөд дөрвөн босоо чихтэй, хойд урд талын чих нь жижиг, хоёр хажуу талын чих арай том байна. Малгайн оройн таван хошууны завсар чихний эмжээр цэнхэр өнгийн хавчаартай байна.

Дөрвөн чихийг хар өнгийн хилэнгээр өнгөлнө. Малгайн оройн багананд нь цагаан мөнгөөр 7.0 см-ийн урттай таван галын дөлийг дээш нь бадруулан босгож, үзүүр дээр нь бат бөх байхыг бэлгэдсэн 0.5 см-ийн зузаантай хоёр цагираг байх ба нийт 1.0 см зузаан хоёр цагирагны дээр монгол үндэстэн, ястнууд эв нэгдэлтэй байхыг бэлгэдэж сампинг мөнгөөр цутгаж хийх ба сампингийн өндөр 4.0 см байна.


Малгай урд талын чихэн дээрээ мөнгөн харцага шувууны дүрсийг 5.5 см-ийн голчтой дугуй дээр хагас товойлгож урласан тэмдэгтэй байна. Малгайн залаа нь улаан өнгөтэй хос залаа байх бөгөөд урт нь 55 см, үзүүр талаараа 7.0 см-ийн өргөн, уг хэсгээрээ 3.5 см-ийн өрнөгтэй байна. Өнгөн талын залаа цулгуй, хоёр дахь залаан дээр үзүүр талаасаа 0.5 см-ийн зай үлдээгээд бага шөвөгт үлдсэн буюу 5 давсан бол 0.5 см, дунд шөвөгт үлдсэн буюу 6 давсан бол 1.0 см өргөнтэй шар туузыг амжилтын тоогоор нь хооронд нь 0.5 см-ийн зайтай оёсон байна. Залаанд өөр чимэглэл хийхгүй.

Начингийн малгай: Монгол үндэсний бөхийн начин цолтой бөхийн малгай нь улаан өнгийн эдээр өнгөлсөн, шовх орой бүхий дөрвөн босоо чихтэй, хойд урд талын чих нь жижиг, хоёр хажуу талын чих арай том байна. Малгайн оройн таван хошууны завсар чихний эмжээр цэнхэр өнгийн хавчаартай байна. Дөрвөн чихийг хар өнгийн хилэнгээр өнгөлнө. Малгайн оройн багананд нь цагаа мөнгөөр 7.0 см-ийн урттай таван галын дөлийг дээш нь бадруулан босгож, үзүүр дээр нь бат бөх байхыг билэгдэн 0.5 см-ийн зузаантай нэг цагираг байх ба нэг цагирагны дээр монгол үндэстэн ястнууд эв нэгдэлтэй байхыг билэгдэн, сампинг мөнгөөр цутгаж хийх бөгөөд сампингийн


өндөр 4.0 см байна.

Малгайн урд талын чихэн дээр начин шонхор шувууны дүрсийг 5.5 см-ийн голтой дугуй дээр эгц харуулан товойлгож урласан байна. Зааны малгайн залаа нь улаан өнгөтэй хос залаа байх бөгөөд урт нь 50.0 см, үзүүр талаараа 7.0 см-ийн өргөн, уг хэсгээрээ 3.5 см-ийн өргөнтэй байна.

Өнгөн талын залаа цулгуй, хоёр дахь залаан дээр үзүүр талаасаа 0.5 см-ийн зай үлдээгээд тав давсан бол 0.5 см өргөнтэй, 6 давсан бол 1.5 см өргөнтэй шар туузыг шөвгөрсний тоогоор нь 0.5 см-ийн зайтай оёсон байна. Залаан өөр чимэглэл хийхгүй.



Зодог: Бөхийн зодог нь саран хэлбэрийн, уутан хэлбэрийн гэсэн хоёр янзын эсгүүртэй байна.



-Зодгийг бат бөх зөөлөн эдээр хийх бөгөөд өнгө ба эсгүүрийг тухайн бөх өөрөө сонгож хийхийг зөвшөөрнө.

-Саран хэлбэрийн зодогны эсгүүр нь мөрний үе ил гарахаар, суганы ар хонхорын ухаас дал махнаас хоёр хуруу дээгүүр байхаар байна.

-Уутан хэлбэрийн зодогны эсгүүр нь мөрний үенээс хэтрэхгүй байх ба суганы ар хонхорын ухаас нь дал махыг дарсан байхаар байна.

-Зодгийг өмсөхдөө гэдсээ татаад элэг бүсээ чангалж уяна.

-Аль ч хэлбэрийн зодгийг өмсч гарыг урагш сунгахад суганы ар мөр хоёрт нэг хуруу орох зайтай байх ёстой. Зодогны их бие ба ханцуйны амсрыг шаглаж оёсон байна. Уламжлалын дагуу ширээсийг гурван зэрэгцээгээр шаглаасанд тулган

ширнэ.

-Зодогны ширээсийг шатрын хөлөгний хэлбэрээр ширнэ.

-Ширээс нь 15 эгнээ буюу 8,0 см-ээс илүүгүй байна. Хэрвээ зодгийн өнгө, дотор үрчийх тохиолдол гарвал туулай харайлтыг 15 эгнээнд багтааж ширэхийг зөвшөөрнө.

-Ханцуйны үзүүрийн ширээс нь их биений ширээстэй ижил хэмжээтэй байна.

-Ханцуйг гурав бөгжилж ширэхийг зөвшөөрнө. Гэхдээ их биений дээд ширээснээс 3 см зайтай байна. Ширээсний өргөн нь таван эгнээнээс хэтрэхгүй байна.

-Зодогны ханцуйны үзүүрт уяа хийхийг зөвшөөрнө.

-Зодогны элэг бүсийг мяндас, хөвөн утас, марль, хадагаар гурваар сүлжин хийх бөгөөд ерөнхий голч нь 1,5 см-ээс багагүй байна.

-Зодогны ар талын чимэглэл дөрвөлжингийн хоёр талаар босоо ширээс гурван эгнээгээр хэтрүүлэхгүй хийж болно.

-Зодгонд өөр нэмэлт ширээс хийх, үндсэн ширээсний дундуур давхар ширээс хийх, дотор талд нь утас зангидах, өнгө дотрын хооронд хатуулга цардаж хийхийг хориглоно.

Шуудаг: Бөхийн шуудаг нь дараах шаардлагыг хангасан байна.

-Шуудагны урд талын дээд амсар нь хүйснээс 8,0 см доогуур байна.

-Шуудагны ташаан талын өргөн нь 10,0 см-ээс хэтрэхгүй байна.

-Гуяны арын ухаадас нь өгзөгний махыг таллаж дарсан байна.



-Шуудагны дээд ба доод амсрыг шаггаж оёно. Уяаны зай нь ширээснээсээ 1,5 см-ээс багагүй зайтай байна.

-Шуудагны ар ба өвөр талд нь босоо ширээс гаргахыг зөвшөөрнө.

-Шуудагны уяа гаргах нүхийг савхи буюу илгээр хийж бөглөхийг зөвшөөрнө.

-Шуудагны дээд доод уяаг элэг бүсийн адил зөөлөн эдээр гурваар сүлжинхийх бөгөөд ерөнхий голч нь 1,5 см-ээс багагүй байна.



Гутал: Бөхчүүдийн өмсөх монгол гутал нь түрий зөөлөн, хоншоор нарийвтар, уужуу зайтай, зулаг нарийн өсгий өшиглүүр дунд зэрэг сайраар угалз тавьж сарьсаар 3 эгнээ хавчаар хийх бөгөөд нимгэн наамал ултай байх нь тохиромжтой. Гутлын оймс нь гуталдаа яв

цав тохирсон ар тал нь задгай, нимгэн эсгий буюу шинелийн материалаар хийсэн, цэмбэ даавуун дээр зүү ороож чимэглэсэн бөгөөд савхин дээр сайр сарьсаар угалзхээ хийсэн хараатай байна.

-Бөхийн гутлыг задарч урагдах, хальтрахаас хамгаалах зорилгоор хоншоор зулаг тавгийг нарийн суран хүлэгээр хүлсэн байна. Гутлын хүлгийг суран туухай зангидах буюу битүү цагирагт гурван тийш гогцоолдон үдэх ба хоншоор зулаг өсгий талыг улаан, ногоон өнгийн цэмбэ буюу илгээр бүрсэн байж болно.



Гутлын түрийний дээд хэсгийг дарж чангалах гутал сугарахаас хамгаалах зорилгоор ар эрэн булчиндаа зууван дөрвөлжин ба дугариг хэлбэрийн түрийний боолт булчингийн даралт хэрэглэнэ. Түүнийг

булигаараар хийж сайр сарьсаар угалз хөөн оёод, голоор нь сур сүвлэж аль нэг үзүүрт нь гогцоо буюу хэлтэй арал хийсэн байна.



Нөмрөг: Аварга цолтой бөхчүүд онцгой хүндлэлтэй наадам, барилдаанд цол дуудуулах даваанд нөмрөг хэрэглэдэг

уламжлал байдаг. Нөмрөгийг цэнхэр, ухаа ягаан өнгийн нимгэн, зөөлөн эдээр үзэмжтэй хийдэг ба засуул бөхийг тавихдаа нөмрөгийг тайлан авч үлддэг байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Батсүх, Г. (2002). Монгол бөх. Улаанбаатар
Дамдин, Ц. (1960). Монгол бөх. Улаанбаатар
Нямдорж, Р., Данзан, Д. (2014). Монголын үндэсний бөхийн нэвтэрхий толь. Улаанбаатар